



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 5/49

Хэрлэн сум

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, 131.1.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.13 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2017 оны сумын шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаанд зориулж Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зориулалт бусаар зарцуулалт хийсэн, аудитын олон улсын стандартын үнэн зөв байх батламж мэдэгдлийг зөрчсөн нь аймгийн Аудитын газрын дүгнэлтээр тогтоогдсон тул Дадал сумын Засаг дарга Б.Оюунбаатарт сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж ажиллахыг Дадал сумын Засаг дарга Б.Оюунбаатарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н. ГАНБЯМБА